

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 6 дугаар цэцэрлэг 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/72/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дархан-Уул аймаг 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ч.Мөнхбаяр Утас: 89275858 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
Асуудлыг онцолсон хэсэг .....	3
Аудитын гол асуудал .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	12
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	17
4.1 Ерөнхий зүйл .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
4.5.1 Завсрын аудитын талаар .....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	19
5.1 Төлбөрийн акт .....	18
5.2 Албан шаардлага .....	20
5.3 Зөвлөмж .....	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	21

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын



ДАРХАН УУЛ АЙМГИЙН 6 ДУГААР  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
С.БОЛОРТУЯА ТАНАА

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 117

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант хугацаанд Боловсрол, шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар 21,070.5 мянган төгрөгийн компьютер, ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 8,340.0 мянган төгрөгийн аяга таваг угаагч хүлээн авч, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэж, тайлагнасан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг нэмэгдүүлснээр цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардал 790,871.3 төгрөг болж, өнгөрсөн оны гүйцэтгэлээс 49.4 хувиар өссөн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан Уул аймгийн Дархан сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 68 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 100 хувиар тайлагнасан байна. Мөн улирал бүр Боловсролын газарт ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР




## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>210,671,699.27</b>	<b>300,350,861.75</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>155,136,093.27</b>	<b>244,033,308.75</b>
312	Банканд байгаа бэлэн мөнгө	155,136,093.27	244,033,308.75
3121	төгрөг	155,136,093.27	244,033,308.75
31211	Төрийн сангийн харилцах	155,136,093.27	244,033,308.75
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	
332	Төлбөртэй үйлчилгээний авлага		
3351	Байгууллагаас авах авлага		
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>55,535,606.00</b>	<b>56,317,553.00</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>1,138,700.00</b>	<b>1,078,700.00</b>
3511	Тусгай зориулалттай материал		
3513	Эм боох материал	1,138,700.00	1,078,700.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>54,396,906.00</b>	<b>55,238,853.00</b>
35410	Бичиг хэргийн материал	3,349,399.00	3,429,590.00
35420	Аж ахуйн материал	37,480,987.00	40,772,959.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	-
35440	Түлш, шатах тослох материал		
3545	Барилгын засварын материал		-
3546	Хүнсний материал	13,566,520.00	11,036,304.00
35470	Бусад хангамжийн материал		
36	НӨӨЦ БАРАА		
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,013,620,569.19</b>	<b>2,032,143,766.58</b>
<b>37</b>	<b>УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>		
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,013,620,569.19</b>	<b>2,032,143,766.58</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,764,326,139.01</b>	<b>1,781,661,336.60</b>
39201	Барилга, байгууламж орон сууц	1,792,724,036.90	1,792,724,036.90
39202	Хуримтлагдсан элэгдэл	(139,062,995.46)	(177,274,486.38)
39203	Авто тээврийн хэрэгсэл	-	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	54,927,025.00	88,975,110.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(30,505,997.74)	(28,724,424.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	35,061,589.85	43,606,444.85
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21,374,980.76)	(22,183,316.44)
39214	Бусад үндсэн хөрөнгө	154,521,590.15	138,411,590.15
39215	Хуримтлагдсан элэгдэл	(82,795,258.06)	(54,704,746.78)
39217	Ном	831,129.13	831,129.13
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>249,294,430.18</b>	<b>250,482,429.98</b>
39301	Программ хангамж	1,124,300.00	1,320,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,011,869.82)	(19,570.02)
39303	Бусад биет бус хөрөнгө	249,182,000.00	249,182,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,224,292,268.46</b>	<b>2,332,494,628.33</b>



<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,224,292,268.46</b>	<b>2,332,494,628.33</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	<b>2,224,292,268.46</b>	<b>2,332,494,628.33</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	249,182,000.00	249,182,000.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө		
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	249,182,000.00	249,182,000.00
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	1,904,158,854.41	2,012,361,214.28
51210	Өмнөх үеийн үр дүн	1,904,158,854.41	1,904,158,854.41
51220	Тайлант үеийн үр дүн	-	108,202,359.87
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	70,951,414.05	70,951,414.05
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,224,292,268.46</b>	<b>2,332,494,628.33</b>



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>976,273,523.28</b>	<b>1,305,702,365.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>32,189,500.00</b>	<b>57,759,765.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>32,189,500.00</b>	<b>57,759,765.00</b>
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	12,234,500.00	28,140,000.00
1200042	Тусах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,500,000.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,734,500.00	28,140,000.00
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	19,955,000.00	29,410,500.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		209,265.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>944,084,023.28</b>	<b>1,247,942,600.00</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>904,196,600.00</b>	<b>1,194,455,700.00</b>
	<b>Урсгалт үйл ажилгааны санхүүжилт</b>	<b>904,196,600.00</b>	<b>1,194,455,700.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>39,887,423.28</b>	<b>53,486,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	39,887,423.28	53,486,900.00
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>		
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>852,698,876.71</b>	<b>1,197,500,005.13</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>852,698,876.71</b>	<b>1,197,500,005.13</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>842,146,676.71</b>	<b>1,171,064,389.45</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>535,259,169.00</b>	<b>790,871,282.68</b>
210101	Үндсэн цалин	386,834,454.75	549,346,006.91
210102	Нэмэгдэл	130,853,862.42	204,652,670.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	17,570,851.83	36,872,605.37
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>67,232,437.53</b>	<b>97,967,995.84</b>
210201	Тэтгэврийн даатгал	44,762,600.79	66,867,392.06
210202	Тэтгэмжийн даатгал	5,605,761.00	7,898,626.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,533,823.40	3,933,713.61
210204	Ажилгүйдлийн даатгал	1,112,295.58	3,825,630.17
210205	Эрүүл мэндийн даатгал	11,217,956.76	15,442,633.68
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>34,587,423.28</b>	<b>33,571,784.32</b>
210301	Гэрэл, цахилгаан	11,264,664.24	11,598,662.40
210302	Түлш, халаалт	12,664,135.88	10,557,224.92
210303	Цэвэр, бохир ус	10,658,623.16	11,415,897.00
210304	байрны түрээс		
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16,491,540.00</b>	<b>30,278,075.00</b>
210401	Бичиг хэрэг		351,300.00
210402	Ном		80,000.00

7  
 ХТ05436 @ 9022899

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,491,540.00	29,846,775.00
210408	Бараа материал акталсны зардал		
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>114,920,146.00</b>	<b>143,275,681.00</b>
210501	Хоол хүнс	114,920,146.00	143,275,681.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
210601	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар		
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
210702	Дотоод албан томилолт		
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,843,600.00</b>	<b>3,091,112.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ		
210804	Тээврийн хэрэгслийн татвар		
210805	тээврийн хэрэгслийн оношлогоо		
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,843,600.00	3,091,112.00
210807	Газрын төлбөр		
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>71,812,360.90</b>	<b>72,008,458.61</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,208,150.00	7,901,256.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,883,000.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	58,721,210.90	64,107,202.61
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>10,552,200.00</b>	<b>26,435,615.68</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0.00	0.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>10,552,200.00</b>	<b>24,020,500.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,552,200.00	24,020,500.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>0.00</b>	<b>2,415,115.68</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		2,415,115.68
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>		
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН</b>		
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>123,574,646.57</b>	<b>108,202,359.87</b>



### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>948,584,023.28</b>	<b>1,247,942,600.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,500,000.00</b>	-
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>4,500,000.00</b>	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	<b>4,500,000.00</b>	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,500,000.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>944,084,023.28</b>	<b>1,247,942,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>904,196,600.00</b>	<b>1,194,455,700.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	904,196,600.00	1,194,455,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>39,887,423.28</b>	<b>53,486,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	39,887,423.28	53,486,900.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>798,189,080.81</b>	<b>1,133,965,484.52</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>798,189,080.81</b>	<b>1,133,965,484.52</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>787,636,880.81</b>	<b>1,107,529,868.84</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	<b>529,482,362.71</b>	<b>790,871,282.68</b>
210101	Үндсэн цалин	354,113,024.47	549,346,006.91
210102	Нэмэгдэл	157,765,961.41	204,652,670.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	17,603,376.83	36,872,605.37
210105	Гэрээт ажлын хөлс	-	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>73,009,243.82</b>	<b>97,967,995.84</b>
210201	Тэтгэврийн даатгалын	50,539,407.08	66,867,392.06
210202	Тэтгэмжийн даатгалын	5,605,761.00	7,898,626.32
210203	ҮОМШӨ-ий даатгалын	4,533,823.40	3,933,713.61
210204	Ажилгүйдлийн даатгалын	1,112,295.58	3,825,630.17
210205	Эрүүл мэндийн даатгалын	11,217,956.76	15,442,633.68
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>34,587,423.28</b>	<b>33,571,784.32</b>
210301	Гэрэл, цахилгаан	11,264,664.24	11,598,662.40
210302	Түлш, халаалт	12,664,135.88	10,557,224.92
210303	Цэвэр, бохир ус	10,658,623.16	11,415,897.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материал</b>	-	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>116,086,801.00</b>	<b>140,016,800.00</b>
210502	Хоол хүнс	116,086,801.00	140,016,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
<b>2106</b>	<b>Эд хогшил урсгал засвар</b>	<b>5,300,000.00</b>	<b>9,639,000.00</b>
210601	Багаж техник хэрэгсэл		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		




210604	Урсгал засвар	5,300,000.00	9,639,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	-
210702	Дотоодын томилолт		
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,623,400.00</b>	<b>3,870,900.00</b>
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,623,400.00	3,870,900.00
210807	Газрын төлбөр		
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>27,547,650.00</b>	<b>31,592,106.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,677,450.00	19,581,806.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	4,870,200.00	12,010,300.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>10,552,200.00</b>	<b>26,435,615.68</b>
<b>2131</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>10,552,200.00</b>	<b>24,020,500.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	10,552,200.00	24,020,500.00
213102	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	2,415,115.68
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		2,415,115.68
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	-	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	-
213208	Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан а/хаагчдад дэмжлэг	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	-	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		.
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
<b>3</b>	<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>150,394,942.47</b>	<b>113,977,115.48</b>
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	<b>6,160,700.00</b>	<b>25,079,900.00</b>
223001	Бусад хөрөнгө	6,160,700.00	25,079,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(6,160,700.00)	(25,079,900.00)
8	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	144,234,242.47	88,897,215.48
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,901,850.80	155,136,093.27
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	155,136,093.27	244,033,308.75



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны НИЙТ ДҮН
S01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	249,182,000.00	70,951,414.05	1,780,584,207.84	-	2,100,717,621.89
S02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
S03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл					-
S04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					-
S05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					-
S06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
S07	Тайлант үеийн үр дүн			123,574,646.57		123,574,646.57
S08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	249,182,000.00	70,951,414.05	1,904,158,854.41	-	2,224,292,268.46
D01	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
D02	Дахин илэрхийлсэн үлдэгдэл					-
D03	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					-
D04	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					-
D05	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					-
D06	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					-
D07	Тайлант үеийн үр дүн			108,202,359.87		108,202,359.87
D08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	249,182,000.00	70,951,414.05	2,012,361,214.28	-	2,332,494,628.33




## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>1,417,796,400.00</b>	<b>1,156,630,268.84</b>	<b>(261,166,131.16)</b>	<b>81.6%</b>
21	Урсгал зардлын дүн	1,417,796,400.00	1,131,550,368.84	(286,246,031.16)	79.8%
<b>210</b>	<b>Бараа үйлчилгээний зардал</b>	<b>1,393,775,900.00</b>	<b>1,107,529,868.84</b>	<b>(286,246,031.16)</b>	<b>79.5%</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,007,210,700.00</b>	<b>790,871,282.68</b>	<b>(216,339,417.32)</b>	<b>78.5%</b>
210101	Үндсэн цалин	726,916,300.00	549,346,006.91	(177,570,293.09)	75.6%
210102	Нэмэгдэл	256,913,800.00	204,652,670.40	(52,261,129.60)	79.7%
210104	Урамшуулал	23,380,600.00	36,872,605.37	13,492,005.37	157.7%
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>115,970,300.00</b>	<b>97,967,995.84</b>	<b>(18,002,304.16)</b>	<b>84.5%</b>
210201	Тэтгэврийн даатгал	78,862,200.00	66,867,392.06	(11,994,807.94)	84.8%
210202	Тэтгэмжийн даатгал	9,275,000.00	7,898,626.32	(1,376,373.68)	85.2%
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,638,800.00	3,933,713.61	(705,086.39)	84.8%
210204	Ажилгүйдлийн даатгал	4,638,800.00	3,825,630.17	(813,169.83)	82.5%
210205	ЭМД-ын хураамж	18,555,500.00	15,442,633.68	(3,112,866.32)	83.2%
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>50,704,700.00</b>	<b>33,571,784.32</b>	<b>(17,132,915.68)</b>	<b>66.2%</b>
210301	Гэрэл, цахилгаан	15,483,000.00	11,598,662.40	(3,884,337.60)	74.9%
210302	Түлш, халаалт	18,372,100.00	10,557,224.92	(7,814,875.08)	57.5%
210303	Цэвэр, бохир ус	16,849,600.00	11,415,897.00	(5,433,703.00)	67.8%
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>143,587,000.00</b>	<b>140,016,800.00</b>	<b>(3,570,200.00)</b>	<b>97.5%</b>
210501	Эм	-	-	-	0.0%
210502	Хоол хүнс	143,587,000.00	140,016,800.00	(3,570,200.00)	97.5%
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	-	-	-	0.0%
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>17,500,000.00</b>	<b>9,639,000.00</b>	<b>(7,861,000.00)</b>	<b>55.1%</b>
210601	Багаж хэрэгсэл	-	-	-	0.0%
210602	Тавилга	-	-	-	0.0%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	-	-	0.0%
210604	Урсгал засвар	17,500,000.00	9,639,000.00	(7,861,000.00)	55.1%
2107	Томиллолт, зочны зардал	-	-	-	0.0%
210702	Дотоод томиллолт	-	-	-	0.0%
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр</b>	<b>3,870,900.00</b>	<b>3,870,900.00</b>	<b>-</b>	<b>100.0%</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	-	-	0.0%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-	-	0.0%
210803	Даатгалын үйлчилгээ	-	-	-	0.0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	-	-	0.0%
210805	тээврийн хэрэгслийн оношлогоо	-	-	-	0.0%
210806	мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,870,900.00	3,870,900.00	-	100.0%
210807	Газрын төлбөр	-	-	-	0.0%
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>54,932,300.00</b>	<b>31,592,106.00</b>	<b>(23,340,194.00)</b>	<b>57.5%</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,922,000.00	19,581,806.00	(23,340,194.00)	45.6%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,010,300.00	12,010,300.00	-	100.0%



213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24,020,500.00</b>	<b>24,020,500.00</b>	-	<b>100.0%</b>
2131	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	-	-	<b>0.0%</b>
213101	Засгийн газрын дотоод урсгал шилжүүлэг	-	-	-	<b>0.0%</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>24,020,500.00</b>	<b>24,020,500.00</b>	-	<b>100.0%</b>
213204	ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал	-	-	-	0.0%
213208	хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	-	-	0.0%
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	24,020,500.00	24,020,500.00	-	100.0%
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-	-	0.0%
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-	-	0.0%
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	-	-	-	<b>0.0%</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-	-	0.0%
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-	-	0.0%
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-	-	0.0%
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>25,079,900.00</b>	<b>25,079,900.00</b>	<b>0.0%</b>
	Дотоод эх үүсвэрээр			-	0.0%
	Тоног төхөөрөмж			-	0.0%
	Бусад хөрөнгө		25,079,900.00	25,079,900.00	0.0%
1	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,417,796,400.00</b>	<b>1,245,527,484.32</b>	<b>(172,268,915.68)</b>	<b>87.8%</b>
131	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,349,591,700.00</b>	<b>1,194,455,700.00</b>	<b>(155,136,000.00)</b>	<b>88.5%</b>
131001	Улсын төсвөөс	1,349,591,700.00	1,194,455,700.00	(155,136,000.00)	88.5%
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого				0.0%
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө			-	0.0%
132	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>68,204,700.00</b>	<b>51,071,784.32</b>	<b>(17,132,915.68)</b>	<b>74.9%</b>
132001	Орон нутгийн төсвөөс	68,204,700.00	51,071,784.32	(17,132,915.68)	74.9%
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>				
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	0.00		-	
	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих				
134002	Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих				
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		155,136,093.27		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		244,033,308.75		
1	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0%
3	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0%
4	АЖИЛЛАГСАДЫН ТОО	39.00	39.00	-	100.0%
5	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0%
6	Гүйцэтгэх ажилтан	25.00	25.00	-	100.0%
7	Үйлчлэх ажилтан	13.00	13.00	-	100.0%



## ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн 6 дугаар цэцэрлэг нь сургуулийн өмнөх насны хүүхдийг Аав ээждээ ачлалтай, эх орондоо хайртай элгэмсэг хүнлэг хүүхэд, Эрүүл чийрэг биетэй эрэмгий, эрдэм номдоо хичээнгүй зорилготой хүүхэд, Ардын уламжлалт өв соёлоо нандигнан хадгалах, бахархан хүндэтгэн дээдлэх үзлийг төлөвшүүлэх, Үнэнч шударга хариуцлагатай хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжиж ажиллаж байна.

#### Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Сангийн сайдын “Аргачлал, зардлын норматив батлах тухай” 2022 оны А/23,27 дугаар тушаал зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 53 дугаар тогтоол “Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоол “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 84 дүгээр тогтоол “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 82 тоот тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 104 тоот тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш ажилтанд мөнгөн тэтгэмж олгох”,
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 237 тоот тогтоол “Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”,
- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны А/85, А/34 дүгээр тушаал “Орон тооны хязгаарын жишиг норматив батлах тухай”,
- Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны 115 тоот дугаар тушаал “Цэцэрлэг, ЕБС-ийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх дүгнэх”

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан Уул аймгийн Дархан сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд өөрчлөлт ороогүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн программтай нийцсэн байна. Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх НББ-ийн журам”-ыг үндэслэн 2025 оноос Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулж мөрдөж ажиллана.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан Уул аймгийн Дархан сумын 6 дугаар цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйл, УСНББОУС -ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 108,202.36 мянган төгрөгөөр буюу 4.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	155,136.1	244,033.3	88,897.2
Авлага	-	-	-
Бараа материал	55,535.6	56,317.6	781.9
Үндсэн хөрөнгө	2,013,620.6	2,032,143.8	18,523.2
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>2,224,292.3</b>	<b>2,332,494.6</b>	<b>108,202.4</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,224,292.3	2,332,494.6	108,202.4
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,224,292.3</b>	<b>2,332,494.6</b>	<b>108,202.4</b>

Тайлант онд төрийн сангийн харилцах дансанд 244,033.3 мянган төгрөгийн үлдэгдлэтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 56,317.6 мянган төгрөг болж 781.9 мянган төгрөгөөр өссөн нь Санхүү аудитын шалгалтын тооллогоор илүүдсэн материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан 209.3 мянган төгрөгийн хүнсний материалыг орлогоор бүртгэж, төсвийн хөрөнгөөр 174,126.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үйл ажиллагаанд 173,553.7 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,032,143.8 мянган төгрөг болж 18,523.2 мянган төгрөгөөр өссөн нь БЕГ-ын 2024 оны “Үр дүнгийн нэмэлт урамшууллын санхүүжилт олгох тухай” А/355 тоот тушаалаар 15,026.2 мянган төгрөг, урсгал зардлаас 10,053.7 мянган төгрөг буюу нийт 25,079.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 11 ширхэг 21,070.5 мянган төгрөгийн компьютер, ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 1 ширхэг 8,340.0 мянган төгрөгийн аяга таваг угаагч буюу нийт 21,748.5 мянган төгрөгийн тус тус үнэ төлбөргүйгээр, ОНӨГ-ын даргын 2024 оны А/16 тоот тушаалаар үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 40,094.3 мянган төгрөгийн хөрөнгийг 28,140.0 мянган төгрөгөөр дахин үнэлж, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2024 оны 01-А/313 тоот захирамжаар 18 нэр төрлийн 15,857.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 64,107.2 мянган төгрөгийн хөрөнгийн элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,332,494.6 мянган төгрөг болж 108,202.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Төсвийн шууд захирагч 2024 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,045,078.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 68,204.7 мянган төгрөг нийт 1,113,283.5 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг баталсан байна.

Тайлант онд нийт батлагдсан төсвийг улсын төсвөөр 304,512.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Энэ нь Засгийн газрын тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнтэй холбоотойгоор цалингийн зардлыг 236,054.9 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 29,506.9 мянга, хүүхдийн хоол хүнсний зардлыг 32,549.1 мянга, мэдээлэл технологийн зардлыг 6,382.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,194,455.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 68,204.7 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих 155,136.1 мянган төгрөг буюу нийт 1,417,796.4 мянган төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 53,486.9 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 51,071.8 мянган төгрөгийг зарцуулж, 2415.1 мянган төгрөгийг орон нутгийн дансанд төвлөрүүлж, улсын төсвөөс 1,194,455.7 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 1,105,558.5 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 88,897.2 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,159,045.4 мянган төгрөг буюу 81.7 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд 258,751.0 мянган төгрөгийн зардлыг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	81605-Эрүүл мэндийг дэмжих	2,796.7	2,771.6	(25.1)	99.1%
2	81807- Хүүхдийн хоол хүнс	143,587.0	140,016.8	(3,570.2)	97.5%
3	81816 Хүүхдэд ээлтэй очин бүрдүүлэх зардал	5,022.1	5,022.1	-	100.0%
4	80233 Хүүхэд хамгаалал	1,823.4	1,823.4	-	100.0%
5	81834 Боловсролын стандарт хөтөлбөр	1,133,492.0	895,435.7	(238,056.3)	79.0%
6	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	60,098.9	60,098.9	-	100.0%
7	81823 Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх зардал	2,771.6	390.0	(2,381.6)	14.1%
8	80111 Тогтмол зардал	68,204.7	51,071.8	(17,132.9)	74.9%
<b>Нийт дүн</b>		<b>1,417,796.4</b>	<b>1,156,630.3</b>	<b>(261,166.1)</b>	<b>81.6%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Ахмад настны тухай хуулийн 14.7-д "Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална" гэж заасан заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд тус цэцэрлэг нь удирдах 1 ажилтан, гүйцэтгэх 25 ажилтан, үйлчлэх 13 ажилтан буюу нийт 39 ажилтантайгаар ажиллаж, 210901-Бараа үйлчилгээний бусад зардалд 12,4721.3 мянган төгрөгийг зарцуулж, худалдан авах ажиллагаатай холбоотой гэрээ шууд байгуулахаар 20,275.2 мянган төгрөг, харьцуулалтын аргаар 62,500.5 мянган төгрөгийн ажил, үйлчилгээ төлөвлөж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ч нэг оролцогч ирээгүй байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан оролцогч ирээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Дархан Уул аймгийн Дархан сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн аудитаар Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Ч.Мөнхбаяр гүйцэтгэж анхан шатны хяналтыг чанарын менежер Т.Эрдэнэтуяа, захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан Уул аймгийн Дархан сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ЦЭСБ-Аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн тайланг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 852,698.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 8,526.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Дархан-Уул аймгийн Дархан сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны төсвийг зарцуулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээллээс 2 мэдээллийг хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.1.1-т “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”, 6.1.3-т “дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны системд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах зөвлөмж хүргүүлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах ...." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу "Ахмадын сан" байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийхэд илрүүлсэн алдаа, зөрчил гараагүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 286.1 мянган төгрөгийн 1 актын биелэлт 100 хувийн хэрэгжилттэй байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	тоо	дүн	тоо	дүн	хувь
Зөвлөмж	1	281.6	1	281.6	100%
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>281.6</b>	<b>1</b>	<b>281.6</b>	<b>100%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 28,809.1 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илрүүлж, аудитын явцад залруулав. Үүнд:

Тайлант оны урсгал санхүүжилтийн орлого 28,809.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжих дансанд тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалт, УСНББОУС-24 "Санхүүгийн тайлан дахь төсвийн мэдээллийн тодруулга", санхүүгийн тайлангийн аудитын "Ангилал", Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул санхүүгийн үр дүн болон мөнгөн

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

гүйлгээний тайланд дээрх дүнгээр урсгал санхүүжилтийг нэмэгдүүлж, орон нутгийн төсвөөс санхүүжилтийг бууруулах бичилт хийж залруулав.

Мөн аудитаар илэрсэн нийт 3,481.0 мянган төгрөгийн зөрчилд<sup>2</sup> төсвийг хохиролгүй болгохоор 539.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, зөрчлийг таслан зогсоох 2,942.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлээ.

### **5.1 Төлбөрийн акт**

**Илрүүлэлт:** Тус цэцэрлэгийн хүүхдийн хоолны махны нормативт хэмжээг 539.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн тооцож олгосон нь Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2020 оны А/166, А/559, 222 тоот “Норматив батлах тухай” тушаалын 2 дугаар хавсралтын 2.1, 2.2-т “Цэцэрлэгийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”-г баримталж ажиллаагүй байна.

### **5.2 Албан шаардлага**

**5.2.1.Илрүүлэлт:** Тайлант онд 2,942.0 мянган төгрөгийн балансын урамшуулал авсан нь Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 Тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-д заасантай нийцэхгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Тайлангийн 4.4.1, 4.4.2-т тусгагдсан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>3</sup>-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>2</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

<sup>3</sup> Шалгадагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж			
	Дүн		Дүн		Дүн		Дүн		Запруулсан		Запруулаагүй		Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайланд онд санхүүжилтийн орлогын ангиллыг 28,809.1 мянган төгрөгөөр буруу тайлагнасан.	1	28,809.1	-	-	1	28,809.1	1	28,809.1	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>28,809.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>28,809.1</b>	<b>1</b>	<b>28,809.1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Дүн		Дүн		Дүн		Дүн		Дүн		Дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус цэцэрлэгийн хүүхдийн хоолны махны норматив хэмжээг хэтрүүлэн тооцож олгосон нь Боловсрол, Шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2020 оны А/166, А/559, 222 тоот "Норматив батлах тухай" тушаалын 2 дугаар хавсралтын 2.1, 2.2-т "Цэцэрлэгийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ"-г заасан заалттай нийцэхгүй байна.	1	539.0	1	539.0								
Тус цэцэрлэгийн эрхлэгч С.Болортуяаг Дархан-Уул аймгийн БГ-ын даргын А/141 тоот тушаалаар 2023 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын дүгнэлтээр "өөрчлөлтгүй" гэж дүгнэгдсэнд нэг сарын цалин 1.5 дахин нэмэгдүүлэн 2,316.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон.	1	2,942.0	-	-	1	2,942.0	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>3,481.0</b>	<b>1</b>	<b>539.0</b>	<b>1</b>	<b>2,942.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
Шилэн дансны цахим системд, байгууллагын батлагдсан төсөв мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	1	-	-	-	-	-	1	-
Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хуртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах ...." гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>-</b>